



Current Situation and Potential for Improvement in Self-Directed Learning of Middle School Students

Otgontuya Dorjkhuu and Zorigtbaatar Tergelsaran

EasyChair preprints are intended for rapid dissemination of research results and are integrated with the rest of EasyChair.

May 24, 2024

1. Хураангуй

“Бие даан суралцахуй” нь “хувь хүний сургалт”, “сурагч төвтэй сургалт”, “сурахад суралцахуй” “өөрийн удирдлагатай суралцахуй” зэрэг орчин үеийн боловсролын үзэл баримтлал, өргөн хүрээний бодлогын хөтөлбөрүүдтэй шууд холбоотой. “Бие даан суралцахуй” нь нь өндөр чанартай, насан туршийн боловсрол (З.Тогтохмаа, 2014)¹, нийгмийн тэгш байдал, эв нэгдлийг дэмжих сургуулийн боловсролын тогтолцоог тасралтгүй хөгжүүлэхэд “хувь хүний боловсрол”-ын чухал элементүүдийн нэг юм.

Сурагчид суралцах замынхаа янз бүрийн үе шатуудаас шалтгаалан бага болон дунд сургуулиуд суралцах үйл явцыг хувь хүнд тохируулахад өөр өөр сорилтуудтай тулгардаг. Суралцахуйн үнэлгээ, сурах арга барил, сурагчийн дуу хоолой зэрэг нь сургалтын үйл ажиллагааг бүхэлд нь сайжруулж хөгжүүлэх арга хэрэгсэл юм.

Төлөвлөх, төвлөрөх, өөрийгөө хянах, ухамсарлах, оновчтой хариу үйлдэл үзүүлэх чадварууд нь өсвөр насны хүүхдийн хөгжлийн чухал алхам болох өөрийгөө удирдах чадварын үндэс суурь болдог. Тиймээс сурагчийн бие даан суралцахуйг төлөвшүүлэх, дэмжихийн тулд дээрх ур чадваруудыг алхамчлалтайгаар бий болгон төлөвшүүлэх, сурагч өөрийгөө үнэлдэг, суралцахуйдаа өөрийн ухамсартайгаар, хариуцлагатайгаар суралцдаг хандлага чухал нөлөөтэй.

Түлхүүр үгс: “Бие даан суралцахуй”, “Өөрийн удирдлагатай сургалт”, “Бие даан суралцах загвар”, “Өөрийн удирдлагатай суралцахуйн бэлэн байдлын хэмжүүр”

2. Удиртгал

“Шинэ Монгол” сургууль 2030 он гэхэд “сурагч өөрийн удирдлагатай суралцдаг сургууль” болох зорилгоо 2020 онд тодорхойлсон билээ. Энэхүү зорилго дор, сурагчдын бие даан суралцах чадварыг хөгжүүлэх, өөрөө төлөвлөж, сурлага хөдөлмөртөө эзэн болох дадлыг хэвшүүлэхэд нэн тэргүүнд анхаарч ажиллахаар төлөвлөсөн.

2023-2024 оны хичээлийн жилд Шинэ Монгол дунд сургууль “суралцагч бүрт бие даан суралцах боломжийг бүрдүүлэх, зүрх сэтгэл, оюун ухаан, бие бялдарын өв тэгш боловсрол олгох” зорилгоо биелүүлэхийн тулд “Сурагчийн өөрөө сурах цаг”-ийг танхимын хичээлийн хуваарьт оруулж, цахим сургалтын системд сурагч төлөвлөлтийн хэсгийг байршуулсан. “Сурагчийн өөрөө сурах цаг” нь манай сургуулийн түүхэнд анх удаа хэрэгжүүлж буй үйл ажиллагаа учир дээрх үйл ажиллагааны өнөөгийн байдлыг судалж, үр дүнг тайлагнах, цаашид сайжруулах арга замыг тодорхойлох зорилгоор уг судалгааг хийсэн. Түүнчлэн, “Бие даан суралцахуй”, ялангуяа дунд сургуулийн сурагчдын “Бие даан суралцахуй”-г судалсан судалгаа хомс байсан² нь энэхүү судалгааг гүйцэтгэх шаардлага, үндэслэлтэйг нотолж байна.

3. Судлагдсан байдлын тойм

Өсвөр нас бол өөрийгөө удирдах зан үйлийн эргэлтийн цэг болж байдгаараа онцлог бөгөөд тархины хөгжлийн онолын үүднээс авч үзвэл эдгээр чадварууд нь төлөвлөх, төвлөрөх, өөрийгөө хянах,

¹ ...Хүн амьдралынхаа туршид янз бүрийн арга замаар суралцаж болно гэсэн үзэл, хандлага 1970-аад оноос бий болж насан туршийн боловсрол (Lifelong education) гэх нэр томъёог хэрэглэж эхэлсэн.

² Бид тандан судалгааг хийхдээ гүүгл сколар хайлтын системээр “бие даан суралцах” болон “independent learning” үгсээр хайсан илэрцийн үр дүнг Хавсралт5-аас үзнэ үү.

ухамсарлах, оновчтой хариу үйлдэл үзүүлэх байдлыг багтаадаг. Эдгээр чадварууд нь хүүхдийн хөгжлийн чухал алхам болох өөрийгөө удирдах чадварын үндэс суурь болдог (Ө.Байгаль, 2002).

“Бие даан суралцах” гэсэн ойлголт нь “хувь хүний сургалт”, “сурагч төвтэй сургалт”, “сургалт эзэмших” зэрэг орчин үеийн боловсролын үзэл баримтлал, өргөн хүрээний бодлогын хөтөлбөрүүдтэй холбоотой. Энэ нь өндөр чанартай, насан туршийн боловсрол (З.Тогтохмаа, 2014)³, нийгмийн тэгш байдал, эв нэгдлийг дэмжих сургуулийн боловсролын тогтолцоог тасралтгүй хөгжүүлэхэд “хувь хүний боловсрол”-ын чухал элементүүдийн нэг юм.

Японы нэрт эрдэмтэн Фүкүзава Юкичи “бие даахуй” болоод “биеэ даасан хүн” хэмээхийг “Биеэ даахуй, тусгаар тогтнохуй” гэдэг бол өөрөө өөрийнхөө биеийг эмхэлж, бусдад найдахгүй байхыг хэлнэ. Бусдын санаа бодолд авталгүй, өөрөө элдэв хэргийн зөв бурууг ялгаж салган, өөрийн үйлдэл аягтаа алдаа эндэгдэл гаргадаггүй хүнийг биеэ даасан хүн гэх бөлгөө” гэж тодорхойлсон нь өнөө үед ч ач холбогдолтой хэвээр байна (О.Жаргалсайхан, 2003).

3.1 Бие даан суралцахуйг тодорхойлох

Бие даан суралцахуйг тодорхойлохын тулд судлаачид хэд хэдэн өөр нэр томъёог ашигладаг бөгөөд тэдгээрээс хамгийн түгээмэл нь “өөрийн удирдлагатай сургалт”⁴ юм. Эдгээр ялгаатай нэр томъёо нь суралцаж буй сурагчийн хувийн онцлог, хандлага; суралцахдаа хариуцлага хүлээх хүсэл эрмэлзэлтэй байх; мөн багш нартай хамтран суралцах орчин зэрэг үзүүлэлтийг судалдаг (Candy, 1991; Gorman, 1998; Bates and Wilson, 2002; Perry et al., 2006).

Өөрийгөө зохицуулдаг суралцагчид нь өөрөө эхэлдэг, тууштай, зохион байгуулалттай хүмүүс юм. Тэд онолын зорилгодоо хүрэхийн тулд танин мэдэхүйн олон стратегийн ашигладаг төдийгүй өөрсдийн арга барил, стратегиа хянаж, эргэх холбоонд хариу өгдөг, даалгавар юмуу асуудлыг хэрхэн хүлээн авдгаа өөрчлөх юмуу стратегиа сольдог (А.Орнштейн, 2003).

Бие даан суралцах нь сурагчид зөвхөн ганцаараа бие даан суралцах бус багш нар бие даан суралцах боломжийг олгох, дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг судлаачид онцолдог. Их Британи болон олон улсын судлаачид ихэвчлэн “хамааралтай” болон “бие даасан” суралцагчийн ялгааг судалдаг (Alexander et al, 1992; Boekaerts, 1997; Williams, 2003). Хамааралтай суралцагч⁵ гэдэг нь мэдлэгийг идэвхгүй хүлээн авагч бөгөөд багшийг сургалтын үйл явцын мэргэжилтэн гэж хүлээн зөвшөөрч, өөрийн үүргийг туслах эсвэл хамааралтай гэж үздэг. Харин, бие даан суралцагч нь суралцах үйл явцыг өөрөө удирдан чиглүүлэх, зохицуулахад идэвхтэй оролцдог бөгөөд “бие даан суралцдаг мэргэжилтэн” юм. Винне, Жэймисон-Ноэл (2002) нар багшийн оролцоогүйгээр мэдээлэл боловсруулах чадвараар нь бие даагчийг хараат суралцагчаас ялгах боломжтой гэж үздэг.

3.2 Бие даан суралцах үндсэн элементүүд

Бие даан суралцах үндсэн элементүүд нь суралцагчдын дотоод болон гадаад хүчин зүйлсээс бүрддэг. Гадаад хүчин зүйлд багш, сурагчдын хоорондын харилцааг хөгжүүлэх (Kesten, 1987; Alexander et al., 1992; Boekaerts, 1997; Bates and Wilson, 2002; and Williams, 2003) болон “боломжит орчин” бий болгох явдал юм. (MacBeath, 1993; Gorman, 1998; Williams, 2003). MacBeath бие даан суралцахад шаардлагатай орчны дэмжлэгийн шатлалыг боловсруулсан бөгөөд (MacBeath, 1993, р9) “бие махбодийн орчин” нь энэхүү шатлалын суурь юм. “Биеийн махбодийн орчин” гэдэг нь номын сан, анги танхим зэрэг бие даан суралцах орчинг хэлнэ. Энэ суурь нь багш нарын ашиглаж, удирдаж болох “цаг хугацааны орчин” юм. Түүнчлэн “цаг хугацааны орчин” гэдэгт багш нар сурагчдад тодорхой даалгавар дээр ажиллах хугацааг зааж, чиглүүлэх боломжтой. Дараагийн орчин нь сурагчдын бие даан суралцах хүсэл эрмэлзэл, чадварыг нэмэгдүүлж эсвэл бууруулдаг “үе тэнгийн орчин” юм. Үүний дараа ном, аудио бичлэг зэрэг

³ ...Хүн амьдралынхаа туршид янз бүрийн арга замаар суралцаж болно гэсэн үзэл, хандлага 1970-аад оноос бий болж насан туршийн боловсрол (Lifelong education) гэх нэр томъёог хэрэглэж эхэлсэн.

⁴ Судлаачийн тайлбар: Энэхүү судалгаанд “Self-regulated” гэдэг үгийг “өөрийн удирдлагатай сургалт” хэмээн орчуулан хэрэглэлээ.

⁵ Судлаачийн тайлбар: Энэхүү судалгаанд “Dependent learner” гэдэг үгийг “хамааралтай суралцагч” хэмээн орчууллаа.

сургалтын хэрэглэгдэхүүнд хамаарах “материаллаг нөөц” орно. Эцэст нь, шатлалын дээд хэсэгт багш, зөвлөгчийн зан чанар, мэдлэг, ур чадвар хамаарах “багшийн нөөц” бий.



Зураг 1. Судлаачийн боловсруулалт. Эх сурвалж: Бие даан суралцахад шаардлагатай орчны дэмжлэгийн шатлал (MacBeath, 1993, р9)

3.3 Бие даан суралцах загварууд

Бие даан суралцах загварууд нь сургалтын хэв маягийн тухай онолын ойлголт дээр суурилдаг (Гарднер, 1983; Колб, 1984; Холл, 2005). Сургалтын хэв маягийн олон онолын зарим нь хувь хүн бичих, дүрслэх гэх мэт өөр өөр сурах арга барилтай байдаг гэж үздэг бөгөөд сургалтын тухай энэхүү үзэл баримтлал нь багш, сурагчдын сургалтын үндсэн суурь юм.

Пинтрич (2000) суралцагчдад суралцах үйл ажиллагаагаа төлөвлөх, өөрийгөө хянах, үнэлэхийн ач холбогдлыг онцолсон өөрийн удирдлагатай сургалтын онолын загварыг боловсруулсан. Зиммерман (2002) өөрийгөө удирдан суралцах сэдлийн ач холбогдлыг онцолж, Пинтричийн загварыг өргөжүүлсэн. Зиммерман “сэдэл нь урьдчилан бодох, гүйцэтгэх, эргэцүүлэн бодох гэсэн гурван үе шатанд нөлөөлдөг гэж үздэг бөгөөд эдгээр нь зорилгодоо хүрэх хүртэл хүсэл эрмэлзэлийг бий болгох, дэмжихэд шаардлагатай мэдлэг, ур чадвар юм. Марку, Филиппу нар сурагчдын урам зориг, итгэл үнэмшил нь “сайн дурын стратеги” ашиглахтай холбоотой болохыг тогтоожээ Марку, Филиппу нарын санал болгосон загварт Пинтричийн загвартай харьцуулбал Вольтерс, Розентал нарын тодорхойлсон “сайн дурын стратеги” гэх мэт нэмэлт хэмжигдэхүүнийг багтааснаараа ач холбогдолтой.

Багшлахуй ба суралцахуйн үнэлгээний тайланд (DfES, 2006) хувь хүний сургалтыг онцолсон бөгөөд бие даан суралцах нь хувь хүний арга барилтай холбоотой болохыг онцолсон. Энэхүү тайланд сурагчид суралцах замынхаа янз бүрийн үе шатуудаас шалтгаалан бага болон дунд сургуулиуд суралцах үйл

явцыг хувь хүнд тохируулахад өөр өөр сорилтуудтай тулгардаг гэдгийг тодорхойлсон. Суралцахуйн үнэлгээ, сурах арга барил, сурагчийн дуу хоолой зэрэг нь сургалтын үйл ажиллагааг бүхэлд нь сайжруулж хөгжүүлэх арга хэрэгсэл юм.

Багшийн өгч буй даалгавруудыг сурагч өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж болох бодит хувилбарууд дээр үндэслэх зэргээр сурагчдын идэвхийг нэмэгдүүлж, тэдэнд сурах хүсэл эрмэлзэл, урам зориг өгөх нь тэдний бие даан сурахад эерэгээр нөлөөлнө. Түүнчлэн, багш, сурагчдын хоорондын бат бөх харилцаа нь багш суралцагчийн сонирхол, хэрэгцээнд хариу үйлдэл үзүүлэх, харилцан итгэлцэл, суралцах хамтын хариуцлага юм. Энэхүү хамтын итгэлцэл, хариуцлагыг бат бөх болгохын тулд сургуулийн захиргаа бие даан суралцах аргын талаар багш, сурагчдын санал бодлыг нарийвчлан цуглуулж, шийдвэр гаргалтад ашиглах боломжтой.

3.4 Бие даан суралцахад шаардагдах ур чадвар

Бие даан суралцахад шаардагдах ур чадваруудыг:

- танин мэдэхүйн чадвар,
- мета танин мэдэхүйн чадвар,
- нөлөөллийн чадвар гэж ангилж болно.

Танин мэдэхүйн чадварт ой санамж, анхаарал хандуулах, асуудал шийдвэрлэх зэрэг орно (Карр, 1996; Малон Смит нар, 1996; Боекаертс, 1997; Энтони, 1994; Зиммерман, 1996). Сурагчид бие даан суралцахын өмнө танин мэдэхүйн хөгжлийн тодорхой түвшинд, тухайлбал үндсэн мэдээллийг тайлах чадвартай байх шаардлагатай. Багш нар бие даан суралцахыг дэмжихийн тулд энэхүү танин мэдэхүйн хөгжлийг дэмжих боломжтой.

Мета танин мэдэхүйн ур чадвар гэдэг нь яаж гэдгийг ойлгохтой холбоотой ур чадвар юм. Суралцагчид хэрхэн суралцаж байгаагаа хэлэх, сурагчид суралцахад нь тусалж буй бусад хүмүүсийг олж тогтоох зэргээр суралцах үйл явц явагддаг (Malone and Smith, 1996; Bransford, et al., 2000; Bullock and Muschamp, 2006). Суралцагчид сурч мэдсэнээ бие даан үнэлэхэд мета танин мэдэхүйн чадвар зайлшгүй шаардлагатай. Мета танин мэдэхүй нь суралцагч өмнөө зорилго тавих, түүнийхээ хэрэгжилтийг үнэлэх, үйл ажиллагаандаа өөрчлөлт хийх зэрэг үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь нэг талаас цаг үетэйгээ хөл нийлүүлж, өөрийгөө, өөрийнхөө үйл ажиллагааг өөрчилж хянадаг (ядаж өөрчлөхийг хүсдэг) суралцах хариуцлагыг өөрөө хүлээдэг суралцагч төлөвшихөд тусална (С.ЭнхтүвшинС, 2009).

Нөлөөллийн ур чадвар гэдэг нь үнэ цэнийн тогтолцоог хөгжүүлэх, эдгээр үнэт зүйлсийг өөртөө шингээх, хэрэгжүүлэх зэрэг мэдрэмж, сэтгэл хөдлөлтэй холбоотой ур чадвар юм. Хүсэл эрмэлзэл нь сэтгэл хөдлөлийн хамгийн чухал чадвар гэж тооцогддог бөгөөд бие даан суралцах чадавхийг нэмэгдүүлэхтэй шууд холбоотой (Malone and Smith, 1996; Neber and Schommer Aikins, 2002; Zimmerman, 2002; Bishop, 2006).

3.5 Бие даан суралцахуйн нөлөө

Бие даан суралцахуйн хүрээнд хийгдсэн судалгаанаас дараах үр нөлөө гарчээ. Үүнд:

- Сурлагын гүйцэтгэл сайжирсан (Ван Гринсвен ба Тиллема, 2006; Хиндс, 2007; Шунк, 2005; Аллан нар, 1996)
- Урам зориг, өөртөө итгэх итгэл нэмэгдсэн (Ван Гринсвен ба Тиллема, 2006; Блэк, 2007); насан туршийн боловсролыг өдөөх (Williams, 2003)
- Сурагчид хязгаарлалтыг илүү сайн удирдах чадвар эзэмшсэн (Зиммерман, 2002)
- Багш нарт сурагчдад ялгаатай даалгавар өгөх боломжийг олгосон (Дисон, 2006)

Бие даан суралцах аргыг ашигласнаар сурагчдын бүлгүүдэд тодорхой нөлөө үзүүлж болохыг судалгаагаар нотолсон нь бий. Тухайлбал, хөвгүүд охидыг бодвол гүйцэтгэлийн зорилго, өнгөц буюу өнгөн сурах стратегид илүү дуртай байдаг (Niemi-virta, 1997); авъяаслаг сурагчид бусад сурагчдаас өөрийгөө зохицуулах сургалтын стратеги ашиглах магадлал өндөр байдаг (Рисемберг ба Зиммерман, 1992).

Бие даан суралцах нь онцгой чадвартай сурагчдын хэрэгцээ, ололт амжилтаа хянах мэдрэмж, ахиц дэвшлийг онцлох (Schunk, 1989); мөн нийгмээс гадуурхагдсан хүүхдүүдийн гадуурхлыг эсэргүүцэхэд үр дүнтэй байж болох юм (Weekes and Wright, 1998). Гэхдээ эдгээр судалгааны ихэнх аргууд нь кейс, туршилтын судалгаа гэхээс илүүтэй ажиглалтын аргаар хийгдсэн гэдгийг анхаарах нь чухал.

3.6 Бие даан суралцахуйг хэмжих арга зүй

Судлаачид 1960-аад оноос эхлэн бие даан суралцах хэмжилтийн сэдвийг хөндсөн байдаг (Пиллинг-Кормик, 1995). Бие даан суралцахуйн хэмжүүр нь дараах дэд сэдвүүдийг хамардаг. Үүнд:

(а) танин мэдэхүйн эсвэл сурагчийн хувийн шинж чанарыг үнэлэх тоон хэмжүүр;

(б) сургалтын үйл ажиллагааны тоонд үндэслэсэн дүгнэлтийн хэмжилт;

(в) Бие даан суралцах үйлийн хэмжилтийн арга зүйн баталгаажуулалтын судалгаа Guglielmino Self-directed Learning Readiness Scale (Guglielmino 1978, 1997; Morris, 1997), Oddi Continuing Learning Instrument (1984), Pilling Cormick's (1998, 2000) (Carr, Ponton, & Ingram, 2003; Park & Confessore, 2000; Derrick, 2002);

(г) сонгосон индексээр бие даан суралцах оноо, зан үйлийг тодорхойлох хүчин зүйлс (Confessore, 1991; Long, 1991a; West & Bentley, 1991);

(д) хэмжилтийн арга зүйг шүүмжлэх, хамгаалах (Field 1989; Guglielmino, 1989; Long, 1989b; McCune, 1989).

1977 онд доктор Люси М. Гуглиелмино нарын боловсруулсан өөрийгөө үнэлэх “Өөрийн удирдлагатай суралцахад бэлэн байдлын хэмжүүр” (SDLRS)⁶ нь тухайн хүний өөрийн суралцахуйг удирдах бэлэн байдлын өнөөгийн түвшинг бүрдүүлдэг хандлага, ур чадвар, шинж чанаруудын цогцыг хэмжих зорилготой. Анхны боловсруулагдсан цагаасаа эхлэн Суралцах давуу байдлын үнэлгээ (LPA) гэж нэрлэгдсэн бөгөөд сүүлд “Өөрийн удирдлагатай суралцахуйн бэлэн байдлын үнэлгээ” (SDLRS) нэрээр өргөн хэрэглэгдэж ирсэн.

SDLRS-ийн талаар зарим нэг шүүмжлэл гарсан ч (Brockett, 1987; Field, 1989; Straka & Hinz, 1996) ихэнх судалгаанууд нь уг хэрэгслийн найдвартай байдал, хүчин төгөлдөр байдлыг дэмждэг (Delahaye & Smith, 1995; Finestone, 1987; Long & Agyekum, 1989;)

Бие даан суралцахуйн үр дүнг хэмжих арга зүйн судалгааны ихэнх нь АНУ-аас гаралтай (Schunk and Zimmerman, 1994; Zimmerman, 2002) боловч Их Британид "Сурахад суралцахуй" төсөл (Багшлах, суралцах судалгааны хөтөлбөр, 2008) болон Боловсролын хүрээлэнгийн EPPI-Centre сэтгэн бодох

6 Self-Directed Learning Readiness Scale (SDLRS)- “Өөрийн удирдлагатай суралцахуйн бэлэн байдлын хэмжүүр”

SDLRS-А-г дэлхийн 500 гаруй томоохон байгууллага ашиглаж байна. Энэ хэмжүүрийг Испани (Кастилиан, Колумб, Куба), Франц, Герман, Итали, Солонгос, Малай, Хятад, Япон, Финланд, Грек, Португал, Африк, Орос, Латви, Литва, Фарс, Голланд, Польш, болон бусад хэлээр орчуулан 70,000 гаруй насанд хүрэгчид, 5,000 хүүхдээс SDLRS/LPA дээрх судалгааг авсан. Түүнчлэн 90 гаруй докторын диссертаци зэрэг олон тооны судалгааны ажилд ашиглагдаж ирсэн.

чадварыг шалгах бүлэг зэрэг нь хэмжилтийн арга зүйн чухал хувилбаруудыг санал болгодог (EPPI-Centre, 2004; EPPI-Centre, 2005).

Бие даан суралцахуйн сүүлийн үеийн хандлагад сэтгэн бодох чадварын хөтөлбөр, суралцахуйн арга барил нь сурагчдын сурлагын гүйцэтгэлд ихээхэн эерэг нөлөө үзүүлдгийг судалгаагаар нотолсон нь бий. Гэхдээ ч бие даан суралцах замаар олж авсан амжилтыг бусад хүчин зүйл эсвэл хосолсон хүчин зүйлээс салгах боломжгүй юм (EPPI-Centre, 2004).

4. Судалгааны арга зүй

Бид энэхүү судалгааг Шинэ Монгол сургуулийн 7-р ангийн 5 бүлгийн 150 сурагчаас “Бие даан суралцахуйн бэлэн байдлыг хэмжих” асуулга, баримтын шинжилгээ, мөн судалгаанд хамрагдаж буй сурагчдын “Монгол хэл”, “Математик”, “Англи хэл” судлагдахууны дүнгийн мэдээлэлд баримтын шижилгээ хийж, үр дүнг нэгтгэсэн. Түүнчлэн, тоон судалгааны зэрэгцээ сурагчийн хувийн онцлог, хандлага, зан төлвийг судлах зорилгоор сурлагын үнэлгээгээр дунджаас доогуур үнэлгээтэй сурагчдыг сонгон авч өөрсдийн боловсруулсан “Ажиглалтын хуудас”-аар ажиглалтын судалгааг хийлээ (Хавсралт6).

5. Судалгааны үр дүн

Бид уг судалгааг 28-р үеийн 150 сурагчийн “Сурагч өөрөө суралцах цаг”-ийн үйл ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, судлаач Люси М. Гуглиелмино нарын боловсруулсан “Өөрийн удирдлагатай суралцахуйн бэлэн байдал хэмжүүр”-ийн судалгааг 135 сурагчаас авч, үр дүнг нэгтгэлээ.

Сурагчийн “Өөрийн удирдлагатай суралцахад бэлэн байдал”-ын судалгааг 28-р үеийн нийт 135 сурагчаас авахад дараах байдалтай байна. Өөрийн удирдлагатай суралцахад бэлэн байдал доогуур түвшинд байгаа сурагч 65 буюу нийт сурагчийн 48 хувь, дунджаас доогуур сурагч 28 буюу нийт сурагчийн 21 хувь, дундаж түвшинд байгаа сурагч 27 буюу нийт сурагчийн 20 хувь, дунджаас дээгүүр сурагч 11 буюу нийт сурагчийн 8 хувь, дээгүүр түвшний сурагч 4 буюу нийт сурагчийн 3 хувийг тус тус эзэлж байгаа нь үеийн сурагчийн 70 орчим хувийг өөрөө бие даан суралцахад бэлтгэх, төлөвшүүлэх, тодорхой зааварчилгаа өгөх, өөрөөр нь болон хөндлөнгийн хяналт тавих нэн чухал хэрэгцээ шаардлагатайг илэрхийлж байна.

Өөрийн удирдлагатай суралцахуйн бэлэн байдлын хэмжүүр	Сурагчдын тоо	Эзлэх хувь
Доод	65	48%
Дунджаас доогуур	28	21%
Дундаж	27	20%
Дунджаас дээгүүр	11	8%
Дээд	4	3%
Нийт	135	100%

Хүснэгт 1. 28-р үеийн сурагчдын “Өөрийн удирдлагатай суралцахад бэлэн байдал”-ын судалгааны үр дүн

Өөрийн удирдлагатай суралцахад бэлэн байдлын хэмжүүр




График 1. 28-р үеийн сурагчдын “Өөрийн удирдлагатай суралцахад бэлэн байдал”-ын судалгааны үр дүн

Сурагчийн бие даан суралцахуйн нэг чухал нөлөө бол сурлагын гүйцэтгэлийн ахиц юм. Тиймээс бид судалгаанд хамрагдаж буй сурагчдын “Монгол хэл”, “Математик”, “Англи хэл” судлагдахууны ХШ, УШ-ын дүнгийн мэдээлэлд харьцуулалт хийж, үр дүнг нэгтгэн дээрх 3 судлагдахууны гүйцэтгэлийн дүнгээр сүүлийн 30 байранд эрэмбэлэгдсэн сурагчийг сонгон авч ажиглалтын судалгааг хийлээ (Хавсралт1). Уг судалгаагаар, үеийн сурагчдаас сүүлийн 30 байранд эрэмбэлэгдсэн сурагчийн сурлагын гүйцэтгэлийн дүнгээс харахад математик, монгол хэл, англи хэл хичээлийн шалгалтын дүн жигд өсөлттэй гарчээ (Хавсралт1,2). Энэхүү өсөлтөд нөлөөлсөн нэг хүчин зүйл нь түвшин тогтоох шалгалт, хөндлөнгийн шалгалтын анализад үндэслэн сурагч өөрөө болон багшийн удирдлагатайгаар “Сурагчийн өөрөө суралцах цаг”-аар дунджаар 3-5 удаа дээрх 3 судлагдахууныг давтсаныг “Сурагчийн өөрөө суралцах цаг”-ийг чиглүүлэгч багшийн тэмдэглэлээс⁷ харж болно. Түүнчлэн, ХШ-1, ХШ-2, УШ-ийн гүйцэтгэлээр сүүлийн байранд эрэмбэлэгдсэн 30 сурагчийн монгол хэл, англи хэлний дүн өсөхөд “Сурагчийн өөрөө суралцах цаг”-ийн төлөвлөлтийг тодорхой, нарийн зааварчилгаатайгаар сурагч бүрээр, өөрсдөөр нь боловсруулсан нь нөлөөлсөн гэж дүгнэж болно. Бид сурагчийн бие даан суралцах төлөвлөгөөг сурагчдаар хийлгүүлэхдээ дараах зааварчилгаа, зөвлөгөөг өгсөн. Үүнд:

- Ямар хичээлийн ямар сэдвийг, ямар сурах бичгийн хэддүгээр бүлгийн, хэддүгээр хуудаснаас хийх хугацаа, давтамжийг маш тодорхой бичих
- Өөрөө боловсруулсан төлөвлөгөөгөө өөрөө хянах
- Ойлгомжгүй, эргэлзээтэй асуудлыг ангийн, үеийн найз нөхөд, анги удирдсан багш, мэргэжлийн багшаас асууж, тодруулах гэсэн хүрээнд тодорхой зааварчилгаа, чиглүүлэгч өгч, явцын үйл ажиллагааг хянаж, дүгнэсэн.

⁷ “Шинэ Монгол” дунд сургууль 2023-2024 оны хичээлийн жилд анх удаа дунд сургуулийн 6-8р ангийн сурагчдын бие даан суралцахуйг дэмжих зорилгоор “Сурагчийн өөрөө суралцах цаг”-ийг танхимын хэлбэрээр долоо хоногт 2 удаа нийт 80 минутаар зохион байгуулж байгаа бөгөөд уг үйл ажиллагааг анги удирдсан багш болон үеийн, мэргэжлийн багш нар чиглүүлэн сурагчийн тухайн өдөр ямар хичээлийн ямар даалгавар хийсэн тухай тэмдэглэлийг тухай бүр хөтөлж хэвшсэн.

Мөн, тоон судалгааны зэрэгцээ сурагчийн хувийн онцлог, хандлага, зан төлвийг судлах зорилгоор сурлагын үнэлгээгээр дунджаас доогуур үнэлгээтэй сурагчдыг сонгон авч ажиглалт хийсэн. Ажиглалтаар дараах нийтлэг дүр зураг харагдлаа. Үүнд:

- Шалгалтын дүнгийн ахицтай сурагчийн гэрийн даалгаврын гүйцэтгэл хангалтгүй хэвээр байгаа ч гэрийн даалгавар хийх давтамж, оролдлого нэмэгдсэн.
- Ангийн найз нөхөд, мэргэжлийн багшаас асуух байдал алхам алхамаар нэмэгдсэн.
- Зарим сурагч бие даан суралцахын тулд өөрөө төлөвлөж, өөрийгөө хянах нь чухал гэдгийг ухамсарлаж эхэлсэн.

6. Дүгнэлт

Дунд сургуулийн багш бид суралцагч бие даан сурах чадвар эзэмшин, сэтгэлээ тогтоон суралцах, өөрийгөө таньж мэдэх, зорилгоо олохын тулд эрэл хайгуул хийж, тодорхойлоход нь дэмжин туслах үүрэгтэй билээ. Энэ үүргээ биелүүлэхийн тулд “Шинэ Монгол” дунд сургуулийн онцлог болох Дунд сургуулийн сурагчдын бие даан суралцах чадварыг төлөвшүүлэх, хөгжүүлэх зорилготой “Сурагчийн өөрөө суралцах цаг”-ийн өнөөгийн байдал, сурагчийн өөрийгөө удирдан суралцахад бэлэн байгаа эсэхийг судаллаа.

Сурагчийн “Өөрийн удирдлагатай суралцахад бэлэн байдал”-ын судалгаанд хамрагдсан 135 сурагчаас 65 буюу нийт сурагчийн 48 хувь, дунджаас доогуур сурагч 28 буюу нийт сурагчийн 21 хувь буюу үеийн нийт сурагчдын 69 хувь нь бие даан суралцахад хангалттай бэлэн биш байгаа нь ирэх хичээлийн жилд сурагчдын бие даан суралцахуйг төлөвшүүлэх, сайжруулахын тулд хичээлийн тодорхой зааварчилгаа, чиглүүлэг, “нөхөрсөг хяналт”-ыг бий болгох шаардлагатай байна.

Төлөвлөх, төвлөрөх, өөрийгөө хянах, ухамсарлах, оновчтой хариу үйлдэл үзүүлэх чадварууд нь өсвөр насны хүүхдийн хөгжлийн чухал алхам болох өөрийгөө удирдах чадварын үндэс суурь болдог.

Тиймээс сурагчийн бие даан суралцахуйг төлөвшүүлэх, дэмжихийн тулд дээрх ур чадваруудыг алхамчлалтайгаар бий болгон төлөвшүүлэх, сурагч өөрийгөө үнэлдэг, суралцахуйдаа өөрийн ухамсартайгаар, хариуцлагатайгаар суралцдаг хандлагыг бий болгох нь нэн чухал ач холбогдолтой.

7. Талархал

Энэхүү судалгааг гүйцэтгэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, үнэтэй зөвлөгөө өгсөн Дунд сургуулийн сургалтын менежер, Г.Ганзориг, Карьер хөгжлийн төвийн эрхлэгч Доктор Г.Суурь, НУЗАН-ийн ахлагч Д.Аюушжав болон хамтран ажилласан 28-р үеийн багш нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Abstract

"Independent learning" is directly related to modern educational concepts and broad policy agendas such as "individualized learning", "learner-centered learning", "learning to learn" and "self-directed learning". "Independent learning" is one of the important elements of "individual education" in the continuous development of the school education system that supports high-quality lifelong education (Z. Togtohmaa, 2014), social equality, and unity.

Because students are at different stages of their learning journey, primary and secondary schools face different challenges in personalizing learning.

Learning assessment, learning styles, and student voice are all tools for improving and developing the learning process as a whole. The skills of planning, concentration, self-control, awareness, and rational response form the basis of self-management, an important step in adolescent development.

Therefore, to develop and support the student's independent learning, it is important to develop the above-mentioned skills step by step, the student's self-esteem, and the attitude of self-conscious and responsible learning.

Зохиогчийн тухай

Д.Отгонтуяа нь 2009 онд “Суралцагч байгууллагыг төлөвшүүлэх нь” сэдвээр удирдахуйн ухааны магистрын, 2022 онд “Төрийн үйлчилгээний бүтээмжийн шинжилгээ: Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн жишээгээр” сэдвээр төрийн удирдлагын докторын зэрэг хамгаалсан. Түүний 15 гаруй эрдэм шинжилгээний бүтээл англи, монгол хэлээр эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүлүүдэд хэвлэгдсэн.

Тэрбээр одоо ЕБ-ын “Шинэ Монгол” сургуульд “Нийгэм судлал” хичээл ийн багшаар ажиллаж, судалгааны ажлаа үргэлжлүүлж байна.

3.Тэргэлсаран нь

Эх сурвалжийн жагсаалт

Монгол хэлээр:

- А.Орнштейн. (2003). Идэвхтэй сургалтын стратеги: Багшлах, суралцах. *Боловсрол судлал*, 35.
- З.Тогтохмаа. (2014). "Насан туршийн боловсрол" нэр томъёоны тухайд. In *Боловсрол судлал* (р. 12). УБ: Боловсрол Шинжлэх ухааны академи.
- О.Жаргалсайхан. (2003). Бие даахуйн уур амьсгалыг яаж төлөвшүүлж, хамгаалах вэ хэмээх гутгаар бүлэг. In Б. судлал. УБ: Боловсрол судлал.
- Ө.Байгаль. (2002). Сургалтаар дамжуулан өсвөр насны хүүхдийн өөрийгөө удирдах чадварыг хөгжүүлэх нь. *Боловсрол судлал*, 31.
- С.ЭнхтүвшинС. (2009). Суралцахуйн үзэл баримтлалд гарч буй хувьсал. *Боловсрол судлал*, 35.

Англи хэлээр:

- Alexander, R., Rose, J. and Woodhead, C. (1992). Curriculum organisation and classroom practice in primary schools. London: Department for Education and Skills.
- Bates, I. and Wilson, P. (2002). Family and education: supporting independent learning. *Learning and Skills Research*, 6(1), 3.
- Bishop, G. (2006). True independent learning - an andragogical approach: giving control to the learner over choice of material and design of the study session. *Language Learning Journal*, 33, 40-6.
- Black P., McCormick R., Mary, J. and Pedder, D. (2006). Learning how to learn and assessment for learning: a theoretical inquiry. *Research Papers in Education*, 21(2), 119-32.
- Black, R. (2007). Crossing the bridge - overcoming entrenched disadvantage through student-centred learning. Melbourne: Education Foundation.
- Boekaerts, M. (1997). Self-regulated learning: a new concept embraced by researchers, policy makers, educators, teachers and students. *Learning and Instruction*, 7(2), 161-86.
- Boekaerts, M. (1999). Self-regulated learning: where we are today. *International Journal of Education Research*, 31(6), 445-457.
- Bolhuis, S. and Voeten, M.J.M. (2001).
- Candy, Philip C. (1991). *Self-Direction for Lifelong Learning*. San Francisco: Jossey-Bass, 567 pages.
- EPPI-Centre (2004). Thinking skills approaches to effective teaching and learning: what is the evidence for impact on learners? London: EPPI-Centre, Institute of Education, University of London.
- EPPI-Centre (2005). A meta-analysis of the impact of the implementation of thinking skills approaches on pupils. London: EPPI-Centre, Institute of Education, University of London.
- Field, L. (1989). An investigation into the structure, validity, and reliability of Guglielmino's Self-Directed Learning Readiness Scale. *Adult Education Quarterly*, 39, 125-39. (See also responses by Guglielmino, Long, and McCune).
- Gardner, H. (1983). *Frames of mind: the theory of multiple intelligences*. London: Heinemann.
- Gorman, M. (1998). The 'structured enquiry' is not a contradiction in terms: focused teaching for independent learning. *Teaching History*, 92, 20-5.
- DfES (2006). *Leading and learning at key stage 3*. Nottingham: Department for Education and Skills.
- Kesten, C. (1987). *Independent learning*. Saskatchewan: Saskatchewan Education.
- Kolb, D.A. (1984). *Experiential learning: experience as the source of learning and development*. Englewood Cliffs: Prentice-Hall.
- Long, H. B., & Agyekum, S. K. (1984). Multitrait-multi-method validation of Guglielmino's Self-Directed Learning Readiness Scale. *Proceedings of the Twenty-fifth Annual Adult Education Research Conference*.

MacBeath, J. (1993). Learning for your self: supported study in Strathclyde schools. Strathclyde: Strathclyde Regional Council.

Malone, G. and Smith, D. (1996). Learning to learn: developing study skills with pupils who have special educational needs. London: National Association of Special Education Needs.

Neber, H. and Schommer-Aikins, M. (2002). Self-regulated science learning with highly gifted students: the role of cognitive, motivational, epistemological, and environmental variables. *High Ability Studies*, 13(1), 59-74.

Perry, N.E., Phillips, L. and Hutchinson, L. (2006). Mentoring student teachers to support self-regulated learning. *Elementary School Journal*, 106(3), 237-254.

Pintrich, P.R. (2000). The role of goal orientation in self-regulated learning. In M. 34 Boekaerts, P.R.

Reynolds, J., Carey, L. and Mason, R. (2002). How do people learn? London: CIPD. Risemberg, R. and Zimmerman, B.J. (1992). Self-regulated learning in gifted students. *Roeper Review*, 15(2), 98-101. Scantlebury, E. (2006). Knowing what you don't know. *T-magazine*, 28-30.

Schunk, D.H. (1989). Attributions and perceptions of efficacy during self-regulated learning by remedial readers. Paper presented at the Annual Meeting of the American Educational Research Association, San Francisco, March 1989.

Schunk, D.H. and Zimmerman, B.J. (1994). Self-regulation of learning and performance: issues and educational applications.


Hillsdale, N J: Erlbaum. Seary, C.J. (2004). Pathways to independent learning. *Computer Education*, 86, 8- 12.

Wolf, A. (2010). How to Shift Power to Learners. London: LSN. Wood, E.K. and Millichamp, P. (2000). Changing the learning ethos in school. *Journal of Inservice Education*, 26(3), 499-515.




Zimmerman, B.J. (2002). Becoming a self-regulated learner: an overview. *Theory into Practice*, 41(2), 64-72.

Хавсралт 1. Дүнгийн харьцуулалт, графикаар

Дүнгийн харьцуулалт



Хавсралт 2. Дүнгийн харьцуулалт, графикаар



28-р үеийн сурагчдын “Сурагчийн өөрөө сурах цаг”-ийн төлөвлөлтийн хуудас

[illegible]

Хавсралт 4. "Өөрийн удирдлагатай суралцах бэлэн байдлын хэмжүүр" судалгааны асуулгын хуудас

7-3

Өөрийн удирдлагатай суралцах бэлэн байдлын хэмжүүр

Self-Directed Learning Readiness Scale (SDLRS)

© Lucy M. Guglielmino, 1977

А Асуулгыг бөглөх зааварчилгаа: Энэхүү асуулга нь суралцах сонирхол, суралцах хандлагын талаарх мэдээлэл
и цуглуулах зорилготой. Асуулт бүрийг анхааралтай уншсаны дараа энэ нь таны хувьд хэр зэрэг үнэн гэж бодож
б байгаагаа илэрхийлнэ үү.

Д Дараах асуултуудад зөв буруу хариулт байхгүй бөгөөд та асуулт бүрийн сонголтыг анхааралтай уншиж, таны
мэдэрэмжийг хамгийн сайн илэрхийлэх нэг хариултыг сонгоно уу. Асуулгад цаг хугацааны хязгаарлалт байхгүй
хэдий ч нэг асуултад хэт их цаг зарцуулахгүй байхыг хичээгээрэй.

Хариултуудын тайлбар

- 1 = Надад ийм мэдрэмж бараг төрдөггүй, би үүнтэй санал огт нийлэхгүй байна.
- 2 = Надад ийм мэдрэмж их тохиолдоггүй ч заримдаа ийм зүйл мэдэрдэг.
- 3 = Надад ийм мэдрэмж заримдаа мэдрэгддэг; Бараг тал орчимд нь ингэж санагддаг.
- 4 = Надад ихэнхдээ ийм зүйл тохиолддог; Би ихэнхдээ ийм зүйл мэдэрдэг.
- 5 = Надад үргэлж ийм мэдрэмж төрдөг; Надад ийм мэдрэмж төрөхгүй байх үе маш ховор.

АСУУЛТ

- 1. Сурах нь миний амьдралын хамгийн чухал хэсэг. 3
- 2. Би юу сурахыг хүсч байгаагаа мэддэг. 2
- 3. Би ойлгохгүй зүйлээ харвал түүнээс "зугтдаг". 2
- 4. Би сурахыг хүссэн зүйлийнхээ сурах аргыг олж чаддаг. 4
- 5. Би сурах дуртай. 4
- 6. Би шинэ зүйлийг эхлүүлэхдээ багагүй хугацаа зарцуулдаг. 2
- 7. Хичээлийн цаг дээр багш ангийн бүх сурагчдад яг юу хийх ёстойг хэлж өгөөсэй гэж би үргэлж хүсдэг. 2
- 8. Өөрийгөө хэн бэ, хаана байгаа, хаашаа явах гэж байгаа тухай бодох нь хүн бүрийн боловсролын гол хэсэг байх ёстой гэж би боддог. 2
- 9. Би ганцаараа тийм ч сайн ажилладаггүй. 4
- 10. Би өөрт шаардлагатай мэдээллийнхээ хаанаас авахаа мэддэг. 3
- 11. Би ихэнх хүмүүсээс илүү бие даан аливаа зүйлийг сурч чаддаг. 2
- 12. Надад гайхалтай санаа байгаа ч түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж чаддаггүй. 4
- 13. Би юуг, яаж сурахаа аргаа өөрөө сонгох нь чухал гэж боддог. 3
- 14. Хэцүү хичээл миний сонирхолд төвөг учруулдаггүй, нөлөөлдөггүй. 2
- 15. Миний сурсан зүйлд надаас өөр хэн ч хариуцлага хүлээхгүй. 2
- 16. Би ямар нэг зүйл сайн сурч байгаа эсэхээ ялгаж чаддаг. 4
- 17. Би сурахыг маш их хүсэж байгаа тул өдөрт илүү олон цаг байгаасай гэж боддог. 3
- 18. Хэрэв миний сурахаар шийдсэн зүйл байвал би хэчнээн завгүй байсан ч түүндээ цаг гаргаж чаддаг. 4
- 19. Миний хувьд уншсан зүйлээ ойлгох нь төвөгтэй байдаг. 2

“Хавсралт 5. Бие даан суралцах”, “Independent learning”, “Independent learning in secondary school” нэршилээр “Google scholar” хайлтын системээс хайлт хийхэд илэрсэн илэрцүүд

/scholar.google.com/scholar?start=0&q=бие+даан+суралцах&hl=en&as_sdt=0,5

lar

About 205 results (0.03 sec)

Tip: Search for **English** results only. You can specify your search language in Scholar Settings.

Оюутны бие даалтын ажлын тухайд: Some issues of students' independent work

S Soyoljin, B Myagmarsuren - Mongolian Journal of Foreign ..., 2012 - journal.num.edu.mn
... Оюутныг **бие даан суралцах** чадварт сургахад их, дээд сургууль, коллежийн багш нарын зааж буй хичээлээрээ удирдан хийлгэдэг **бие** даах ажил ихээхэн үүрэгтэй. **Бие** ...
☆ Save  Cite Related articles 

Сургалтын зохион байгуулалтийн онцлог хичээлийн үр дүнд нөлөөлөх нь
Д Номиндарь, Б Энхбаатар... - Scientific transaction of ..., 2017 - journal.num.edu.mn
... сурлагын чанар болоод **бие** хүний төлөвшил нь ... нь **сурах** арга барилд хэр амжилттай суралцсанаас хамаарна. Иймээс их дээд сургуулийн багш бол оюутны **бие даан суралцах** ...
☆ Save  Cite Related articles 

ОРЧУУЛГЫН ОНОЛ, ДАДЛАГА ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ (Герман хэл, судлал мэргэжлээр бакалаврын зэрэг олгох сургалтын ...

J Ariun - Орчуулга зүй, 2018 - journal.num.edu.mn
... оюутны **бие даан** ажиллах сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, **бие даан суралцах** ... олон тооны дасгалыг хийж **бие даан суралцах** нөхцөлөөр хангах зорилгоор орчуулгын ...
☆ Save  Cite Related articles 

https://scholar.google.com/scholar?hl=en&as_sdt=0%2C5&q=independent+learning+in+secondary+schools&c

cholar

About 4,020,000 results (0.16 sec)

Toward a theory of independent learning and teaching

MG Moore - The Journal of Higher Education, 1973 - Taylor & Francis
... in a **school** setting). **"Independent Study in secondary schools"** ... **LEARNING SYSTEM: "THE AUTONOMOUS LEARNER"** Could we define **independent learning** and teaching as **learning** ...
☆ Save  Cite Cited by 1560 Related articles All 3 versions

Effects of computer assisted instruction on independent learning skills of Economics students in secondary schools in Kaduna state, Nigeria

AE Adeniyi, HO Yusuf - European Journal of Alternative Education ..., 2016 - oapub.org
... and the teacher monitors, the **learning** that takes place. The objective of the study among others was to determine the rate at which **independent learning** skills acquisition could be ...
☆ Save  Cite Cited by 16 Related articles All 4 versions 

Toward self-directed learning in secondary schools: What do teachers do?

S Bolhuis, MJM Voeten - Teaching and Teacher Education, 2001 - Elsevier
... Instructional methods facilitating **independent learning** are in the beginning phase of their ... in regular **schools** do things in class that are supposed to stimulate self-directed **learning**. We ...
☆ Save  Cite Cited by 299 Related articles All 8 versions

INDEPENDENT STUDY IN SECONDARY SCHOOLS.

WM Alexander, VA Hines - 1966 - ERIC
... Recent developments in **secondary** education have emphasized the need for ... on **independent learning** and, therefore, on plans of teaching and **learning** which are of an **independent** ...
☆ Save  Cite Cited by 17 Related articles All 2 versions 

[PDF] THE INDEPENDENT LEARNING CENTRE IN THE SECONDARY SCHOOL CONTEXT: HOW DEEP WAS MY LEARNING?

scholar.google.com/scholar?hl=en&as_sdt=0%2C5&q=independent+learning+&btnG=

ar

About 8,080,000 results (0.04 sec)

[PDF] What is independent learning and what are the benefits for students

B Meyer, N Haywood, D Sachdev... - Department for Children ..., 2008 - academia.edu
... **independent learning** and its possible impact on students. The review found a number of different terms to describe **independent learning**, ... management of their **learning**. The authors of ...
☆ Save  Cite Cited by 143 Related articles All 7 versions 

Toward a theory of independent learning and teaching

MG Moore - The Journal of Higher Education, 1973 - Taylor & Francis
... THE **LEARNING SYSTEM: "THE AUTONOMOUS LEARNER"** Could we define **independent learning** and teaching as **learning** at a distance from teaching? We believe not. To focus ...
☆ Save  Cite Cited by 1560 Related articles All 3 versions

Independent learning--what we do when you're not there

C Hockings, L Thomas, J Ottaway... - Teaching in Higher ..., 2018 - Taylor & Francis
... **Independent learning** is one of the cornerstones of UK higher education yet it is poorly ... of **independent learning** and how they may become more effective **independent learners**. This ...
☆ Save  Cite Cited by 138 Related articles All 9 versions

Does higher education promote independent learning?

L Gow, D Kember - Higher education, 1990 - Springer
... does promote the ability of students to act as **independent learners**. For convenience ... **independent learner** than adopting a deep approach, but it is a precondition of **independence** ...
☆ Save  Cite Cited by 482 Related articles All 7 versions

Related searches

students independent learning independent learning **secondary schools**
independent learning **primary school**

“Хавсралт 6. Сурагчийн бие даан суралцахуйг ажиглах хуудас

Сурагчийн бие даан суралцахуйг ажиглах ажиглалтын хуудас

Үнэлгээ:
Хангалттай:Хта
й
Хангалтгүй:Хгү
й
Сайжирч
байгаа:Сб

Боловсруулсан:
З.Тэргэлсэран
Д.Отгонтуяа

№	Код	Танин мэдэхүйн чадвар									Мета танин мэдэхүйн чадвар						Нөлөөллийн чадвар					
		Ойлгох чадвар			Асуух, хариулах, бусадтай харилцах чадвар			Асуудал шийдвэрлэх чадвар			Зорилго, төлөвлөгөө боловсруулсан эсэх			Өөрийгөө, төлөвлөгөөгөө үнэлэх, хянах			Сурах хүсэл эрмэлзэл			Мэдэрэмж, сэтгэл хөдлөлөө илэрхийлдэг эсэх		
		Нийгэм судлал хичээл			Нийгэм судлал хичээл			Нийгэм судлал хичээл			Нийгэм судлал хичээл			Нийгэм судлал хичээл			Нийгэм судлал хичээл			Нийгэм судлал хичээл		
		4-р сарын 1-р дол оо хон ог	4-р сарын 2-р дол оо хон ог	4-р сарын 3-р дол оо хон ог	4-р сарын 1-р дол оо хон ог	4-р сарын 2-р дол оо хон ог	4-р сарын 3-р дол оо хон ог	4-р сарын 1-р дол оо хон ог	4-р сарын 2-р дол оо хон ог	4-р сарын 3-р дол оо хон ог	4-р сарын 1-р дол оо хон ог	4-р сарын 2-р дол оо хон ог	4-р сарын 3-р дол оо хон ог	4-р сарын 1-р дол оо хон ог	4-р сарын 2-р дол оо хон ог	4-р сарын 3-р дол оо хон ог	4-р сарын 1-р дол оо хон ог	4-р сарын 2-р дол оо хон ог	4-р сарын 3-р дол оо хон ог	4-р сарын 1-р дол оо хон ог	4-р сарын 2-р дол оо хон ог	4-р сарын 3-р дол оо хон ог
1	БДСС2 8001	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб
2	БДСС2 8002	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб
3	БДСС2 8003	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб
4	БДСС2 8004	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб
5	БДСС2 8005	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Хгү й
6	БДСС2 8006	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб
7	БДСС2 8007	Хгү й	Сб	Сб	Хгү й	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб
8	БДСС2 8008	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й
9	БДСС2 8009	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб
10	БДСС2 8010	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб
11	БДСС2 8011	Хгү й	Сб	Хта й	Сб	Сб	Хта й	Сб	Сб	Хта й	Сб	Сб	Хта й	Сб	Сб	Сб	Сб	Сб	Сб	Сб	Сб	Сб
12	БДСС2 8012	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Хгү й
13	БДСС2 8013	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб
14	БДСС2 8014	Хгү й	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Хгү й
15	БДСС2 8015	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Хгү й	Сб
16	БДСС2 8016	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб
17	БДСС2 8017	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб
18	БДСС2 8018	Хгү й	Сб	Хта й	Сб	Сб	Хта й	Сб	Сб	Хта й	Сб	Сб	Хта й	Сб	Сб	Сб	Сб	Сб	Сб	Сб	Сб	Хгү й
19	БДСС2 8019	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб
20	БДСС2 8020	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб
21	БДСС2 8021	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Хгү й	Сб
22	БДСС2 8022	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб
23	БДСС2 8023	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й
24	БДСС2 8024	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб
25	БДСС2 8025	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Сб	Хгү й	Хгү й	Сб
26	БДСС2 8026	Хгү й	Сб	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Сб	Сб	Сб	Сб	Сб	Сб
27	БДСС2 8027	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Хгү й
28	БДСС2 8028	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Хгү й	Хгү й	Хгү й	Сб	Сб
29	БДСС2 8029	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Сб	Хгү й	Сб	Хгү й
30	БДСС2 8030	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Хгү й	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб	Хгү й	Сб	Сб